



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН

2020

АГУУЛГА /

МЭНДЧИЛГЭЭ

2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

ГИШҮҮНЧЛЭЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

СУДАЛГАА

АРГА ХЭМЖЭЭ

ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

СУРГАЛТ

ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ХАВСРАЛТ

ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ХИЙСЭН АЖЛУУД



ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

**МҮХАҮТ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ
2020–2023**

ЕРӨНХИЙЛӨГЧ	ИЛ ТОД МАНЛАЙЛАЛ	Ил тод стратегийг ил тод манлайллаар хэрэгжүүлнэ
THINK TANK CLUB	БИЗНЕСИЙН ОРЧНЫ БОЛОН САЛБАРЫН БОДЛОГЫН ШИЙДЭЛ ГАРГАДАГ БОЛОХ	Бизнесийн орчны болон бодлогын шийдлийг тодорхойлох чадамжтай байх Бодлогод нөлөөлдөг байх
SME САНХҮҮЖИЛТ	САНХҮҮЖИЛТИЙН ШИЙДЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА БОЛОХ	Санхүүжилтийн шийдэл Гадаад худалдаа, экспортыг дэмжих
ОРОЛЦООНД СУУРИЛСАН ШИЙДЭЛ / ГИШҮҮД/	ОЛОН НИЙТЭД НӨЛӨӨ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БАЙЖ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨХ	Бүтцийн өөрчлөлт (Газарзүйд суурилсан → Үнэ цэнэд суурилсан) Гишүүн нэмэгдүүлэх (5000 → 50000)



МЭНДЧИЛГЭЭ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн
Танхимын Ерөнхийлөгч О.АМАРТҮВШИН

Дэлхий дахинд цар тахлын улмаас хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засгийн хувьд хүнд сорилт тулгарсан 2020 оныг Монголчууд бид бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы дунд УИХ-ын сонгууль, шинэ Засгийн газрыг байгуулах нийгэм улс төрийн олон үйл явдалтай, эдийн засаг бизнесийн олон асуудал, бэрхшээлтэйгээр ардаа орхиж байна.

МҮХАҮТ-ын хувьд хөрш Хятад улсад Ковид-19 вирусийн халдвар гарсан цагаас эхлэн хөл хорионы бизнес дэх нөлөөллийн судалгааг удаа дараалан явуулж, эдийн засгийн эрсдэлийг удирдах, цар тахлын нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх саналуудыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газарт, яамдад тухай бүр нь хүргүүлэн ажилласан бөгөөд энэ дагуу тодорхой шийдвэрүүд гарч үр дүнд хүрсэн. Ялангуяа хатуу хөл хорионы үед бизнесийг шат дараатай нээх, хилийн боомтууд дээр үүссэн асуудлыг шийдвэрлүүлэх, аж ахуйн нэгжүүдэд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх талаар Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисстой хамтран ажилласан юм.

2020 онд МҮХАҮТ байгуулагдсаны 60 жил, Арбитрын 90 жилийн ой тохиосон бөгөөд түүхэн ойг тэмдэглэх арга хэмжээ өндөр хэмжээнд болж өнгөрсөн. МҮХАҮТ-ын 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бизнесийн салбарын 70 гаруй хүнийг төрийн дээд одон медалиар шагнаан урамшуулсны дотор хөдөлмөрийн баатар 3, салбарын гавьяат 11 төрсөн нь бизнесийнхний хувьд бахархалтай том үйл явдал болсон юм.

Дижитал шилжилтийн нөлөөгөөр хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж бизнесийг хөтлөн авч явах шинэ үеийн гүйцэтгэх захирал, менежерүүдийг бэлтгэх зорилгоор танхимын дэргэдэх Бизнесийн академийг шинэчлэн зохион байгуулсан бөгөөд Харвард Бизнес сургуулийн Пабблишингийн менежерүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын манлайллын холимог хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа. Мөн шинэлэг агуулга хэлбэр бүхий “Executive summit 2020” виртуал сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан юм.

Танхимын гишүүнчлэлийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбараар дагнасан танхимуудыг байгуулахад чиглэсэн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлэн болгоод байгаа бөгөөд энэ нь бизнес эрхлэгчид улам бүр нэгдэн нягтрах нөхцөлийг ийнхүү бүрдүүлэх нь төр засагт нэгдсэн дуу хоолойгоо хүргэх, шийдвэр гаргалтын түвшинд хүчтэй нөлөөлөл үзүүлэхэд том алхам болно гэж үзэж байна.

2021 он эдийн засаг, бизнест тулгарсан сорилтуудыг давж бизнесээ эргэн сэргээхэд чухал цаг үе бөгөөд бид хамтдаа хийж чадна гэдэгтээ итгэл дүүрэн байна.

МЭНДЧИЛГЭЭ

*Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн
Танхимын дарга Т.ДҮҮРЭН*



МҮХАҮТ нэгэн жарныг үдэж, нэгэн шинэ жарны хуудсыг эхлүүлсэн түүхэн цаг үе өнгөрсөн жил тохиож, гишүүн байгууллагууд, хамт олон, бизнес эрхлэгчид, түншүүдийн хамт өнгөрснийг дүгнэж, ирээдүйг тодорхойлон, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв.

МҮХАҮТ-аас 2020 онд бизнесийг дэмжих зорилтын хүрээнд хийхээр төлөвлөж байсан гадаад дотоод уулзалт, үзэсгэлэнгийн олон арга хэмжээнүүд цар тахлын улмаас хойшлогдож, цуцлагдсан хэдий ч бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, нэгдлийг хангах болон экспортыг дэмжих чиглэлээр тодорхой үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүллээ.

Эдийн засгийг эрчимжүүлэх систем динамикийн мэдлэгт суурилсан загварыг танхимаас гаргаж, эдийн засгийг эрчимжүүлэх саналыг Монгол улсын Их хурал, Засгийн газарт танилцуулсан. Хувийн хэвшил түүнд ажиллагсдын эв санааны нэгдлийг илэрхийлэх, дуу хоолойг нь төрд хүргэх зорилготой “Ажлын байраа хамгаалцгаая” уриатай Май-1 цахим жагсаал ба “Эзнээ хүлээсэн багаж хэрэгслийн жагсаал”-ыг амжилттай зохион байгуулсан билээ.

Аж ахуйн нэгжүүд мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэгдэх, мэдээллээ эмх цэгцтэй нэг байршилд төвлөрүүлэн нийтэд хүргэх TradeMongolia.MN үндэсний хэмжээний вэб хуудсыг санаачлан хийсэн бөгөөд бизнест учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар энэ хуудсаар авах өргөдөл гомдол нь олон нийтээс дэмжлэг авснаар холбогдох байгууллагад хүргэж шийдвэрлүүлэх боломжтой болох юм.

Европын Холбооны санхүүжилттэй Монгол Улсын худалдааг дэмжих–ТРАМ төслийн хүрээнд гоо сайхан, чацаргана, торомны тоос/сарлагийн хөөвөр, арьс ширний кластерыг байгуулан үйл ажиллагааг дэмжиж байгаа бөгөөд 2020 оны 11 дүгээр сард Берлин хотноо “Монголын мэдээлэл, худалдааг дэмжих төв”-ийн “Mongolian green labels” дэлгүүр нээлтээ хийсэн. Мөн Германы ХАҮТ-ын Холбооны хамтын ажиллагааны төслийн хүрээнд Увс аймагт чацарганын, Архангай аймагт хонины ноосны кластер багуудын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг дэмжин ажиллаж байна.

Хушин ойн дагалт баялаг болох самар, самрын бүтээгдэхүүний нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл ба экспортын орчинг сайжруулж, бие даасан кластер хэлбэрээр хөгжүүлэн өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор Танхимын дэргэд самрын кластерыг байгуулсан. Энэ нь байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтад аж ахуйн нэгжүүдийн оролцоо, хариуцлага нэмэгдэхийн зэрэгцээ Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргасан сайн жишиг болно гэж үзэж байна.

МҮХАҮТ-аас гаргасан санал санаачилга, үйл ажиллагааг дэмжин ажилладаг нийт гишүүд, Удирдах Зөвлөл, Тэргүүлэгч гишүүд Та бүхэндээ талархсанаа илэрхийлье.

2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Монгол улс Европын Холбооны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчийн систем”-ийг нэвтрүүлж уг системийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Танхим хэрэгжүүлж эхлэв.
- МҮХАҮТ-аас Засгийн газар, УИХ-д Эдийн засгийн эрсдэлийг удирдах 5 багц, 21 санал хүргүүлсэн.
- МҮХАҮТ нь 1878 онд байгуулагдсан 31000 гаруй гишүүнтэй Олон Улсын Барааны Тэмдэг Эзэмшигчдийн Холбоонд /International Trademark Association/ гишүүнээр элслээ.
- Ажлын байрыг хадгалах “Эзнээ хүлээсэн багаж хэрэгсэл”-ийн тайван жагсаал зохион байгуулав. Уг жагсаалд цахимаар 20000 гаруй иргэд, 2000 гаруй ААН, 1000 гаруй багаж хэрэгсэл оролцсон.
- Монгол улсад вирусын халдвартай холбоотой хорио цээрийн арга хэмжээг авсан цагаас эхлэн бизнес ба ажлын байранд үзүүлж байгаа үр нөлөөний судалгаануудыг хийж судалгааны тайлан, санал зөвлөмжүүдийг гаргаж танилцуулсан.
- ТОП-10 ААН-ийн уулзалт зохион байгуулж, эдийн засгийг эрчимжүүлэх тунхаг бичигт гарын үсэг зурсан.
- 2020-2024 онд эдийн засгийг эрчимжүүлэх “ЭЗЭН-900” хөтөлбөр боловсруулж, УИХ-ын 2020 оны сонгуульд өрсөлдөх нам эвслүүдийн мөрийн хөтөлбөрт тусгах саналын хамтаар нэр дэвшихээ мэдэгдсэн улс төрийн намуудад хүргүүлсэн.
- МҮХАҮТ, МУИС-ийн Бизнесийн сургууль хамтран Монгол улсын бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, бизнесийн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох зорилгоор “Монголын бизнесийн орчны судалгаа”-г хоёр дахь удаагаа явуулав.
- УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар бүрэлдсэн УИХ-ын гишүүд, ЗГ-ын гишүүдтэй Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар бизнес эрхлэгчидтэй санал солилцох уулзалт зохион байгуулсан.
- МҮХАҮТ үүсэн байгуулагдсаны 60 жил, Арбитрын 90 жилийн ой тохиосон бөгөөд түүхэн ойн арга хэмжээг өндөр хэмжээнд зохион байгуулав. Ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бизнесийн салбарын 70 гаруй хүнийг төрийн дээд одон медалиар шагнаан урамшуулсны дотор хөдөлмөрийн баатар 3, салбарын гавьяат цолоор 11 хүн шагнагдсан.
- Монгол улсад Арбитрын байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ой тохиож, Монголын Олон Улсын Арбитр түүхэндээ хамгийн олон буюу 107 хэрэг шинээр хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явууллаа.
- “Ази, номхон далайн худалдааны хэлэлцээр ба Монгол улс” семинар зохион байгуулагдаж АРТА буюу АНДХХ-ийн гарал үүслийн гэрчилгээг 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс Танхим олгохоор болов.
- Бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед эдийн засаг, бизнест учирч буй эрсдэлийг удирдах 4 багц 28 саналыг боловсруулж УИХ, МУ-ын ЗГ-т хүргүүлсэн.
- “Малчдад ээлтэй төр” төслийг Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь аймгийн 11 сумдад хэрэгжүүлсэн.
- МУ-ын шадар сайд, УОК-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 153 тоот тушаалаар УОК-ын дэргэд “Бизнесийн зөвлөх зөвлөл” байгуулагдсан.
- Хяналтын байгууллагын ажиллагаанд тавих шаардлага MNS ISO/IEC 17020:2013 стандартыг экспорт, импортын бараанд хөндлөнгийн хяналт шалгалт хийх экспертизийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.
- Харвардын манлайллын хөтөлбөрийн гэрээнд гарын үсэг зурав. Байгууллагын гүйцэтгэх удирдлага, дунд шатны менежерүүд, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан “1000 CEO, 1000 хүчирхэг компани” хөтөлбөрийн хүрээнд МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес академи Харвардын Бизнесийн сургуулийн хөтөлбөрийг албан ёсны эрхтэйгээр Монголд нэвтрүүлж байгаа бөгөөд энэ ажлын эхлэл болгон “Executive summit 2020” виртуал сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулав.

БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

Бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төслүүдийг боловсруулах чиглэлээр нийт 8 хуулийн төсөл, 6 бодлогын баримт бичиг, журамд санал өгсөн, 15 санал боловсруулж төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн ба 20 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 5 уриалга, мэдэгдэл гаргасан.

Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд ААН-үүдийн үйл ажиллагаа бүр болон түр хугацаагаар зогсох буюу хязгаарлагдаж, борлуулалтын орлого эрс буурсан, ажилтнуудын цалин, үйл ажиллагааны зардал, түрээс, зээл бусад төлбөр төлөхөд шууд хүндрэл үүсэж, бизнесийн орчин хүндхэн байсан ба Танхим эдийн засаг, бизнест учирч буй эрсдэлийг бууруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, ажлын байрыг хадгалах чиглэлээр идэвхтэй ажиллав.

Монгол улсын 2020-2024 онд эдийн засгийг эрчимжүүлэх “ЭЗЭН-900” хөтөлбөр боловсруулж УИХ-ын 2020 оны сонгуульд өрсөлдөх нам эвслүүдийн мөрийн хөтөлбөрт тусгах саналын хамтаар нэр дэвшихээ мэдэгдсэн улс төрийн намуудад хүргүүлсэн.

Бизнес эрхлэгчид салбарын болон тодорхой асуудлаар санаа солилцох, бодлогын өмгөөллийн чиглэлээр нэгдэх, салбарын төрийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилго бүхий 22 бизнесийн зөвлөл /Хавсралт 1/ Танхимын дэргэд ажиллаж байна.

2020 онд МҮХАҮТ-ын төлөөлөл нийт 20 хороо, ажлын хэсэгт /Хавсралт 2/ гишүүнээр орж ажилласан.

Санал өгсөн хуулийн төсөл

1. Монгол улсын 2020 оны нэгдсэн төсвийн тодотгол
2. Монгол улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөл
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Арилжааны тухай хууль
5. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020-2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл
6. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль
7. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль
8. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль
9. Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Санал өгсөн бодлогын баримт бичиг, журам

1. Төрийн албаны дэргэдэх Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийн төсөл
2. Монгол улсын засгийн газраас ГШХО-ын талаар баримтлах чиглэлийн төсөл
3. “Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал-Алсын хараа 2050” баримт бичгийн төсөл
4. “Монгол улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах стратеги төлөвлөгөө”-ний төсөл
5. Зээлийн батлан даалтын сангийн журмын төсөл
6. Монгол улсын худалдааны бодлогыг хянан үзэхэд өгөх тайлбар

Боловсруулж холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн санал

1. БНХАУ-д туслах аянд малчдыг уриалах санал
2. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд гарч болох хомсдол, үнийн өсөлтөөс сэргийлэх арга хэмжээний санал
3. Эдийн засгийн эрсдэлийг удирдах 5 багц 21 санал
4. Ноолуурын салбарыг дэмжих санхүүгийн хөтөлбөрт санал
5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн одоогийн байдал, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх санал
6. Махны экспортыг нэмэгдүүлэх санал
7. Эдийн засгийн гол салбаруудад тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх

8. Монгол улсын их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох намуудын мөрийн хөтөлбөрт өгөх санал
9. “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-ыг шинэчлэх, зайг шинэчлэн тогтоох санал
10. Бүх нийтийн бэлэн байдлын үед эдийн засаг, бизнест учирч буй эрсдэлийг удирдах багц 4 багц 25 санал
11. Эдийн засаг, бизнесийг үе шаттай сэргээх санал

Мэдэгдэл, уриалга

1. Бизнесийнхэн хамтдаа хүндрэлийг даван туулахыг уриалав
2. Бизнесийг түр хаасан онцгой нөхцөл байдлыг хүлээн авахыг уриалав
3. Бизнесийн холбоод, ТББ-ууд хамтарсан мэдэгдэл гаргав
4. ТОП-ААН-үүд хамтарсан мэдэгдэл гаргав
5. “Монголын Ноосон Бүтээгдэхүүн Үйлдвэрлэгчдийн Холбоо”-той хамтран уриалга гаргав

Хэлэлцүүлэг уулзалт


1. Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэг
2. “Эдийн засгийн коридорт чөлөөт бүс холбогдох нь” форум
3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортлогчидтой хийсэн уулзалт
4. Монгол улсын их хурлын дарга Г.Занданшатарын хүнсний болон эм эмнэлгийн хэрэгслийн бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт
5. Бизнесийг дэмжих байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хийсэн уулзалт
6. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар бизнес эрхлэгчидтэй санал солилцох уулзалт
7. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-ийн 14.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хүнсний салбарын бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа асуудлаар Татварын ерөнхий газартай хийсэн цахим уулзалт

ГИШҮҮНЧЛЭЛ

2020 онд МҮХАҮТ-ын нийт гишүүдийн тоо 5133 болж өссөн. Үүнээс орон нутгийн гишүүн байгууллагын тоо 3020, Улаанбаатар хотын гишүүн байгууллагын тоо 2113 болж өмнөх оноос 775 буюу 17.8 хувиар нэмэгдэв.



Шинэ үйлчилгээ www.trademongolia.mn




Үндэсний хэмжээний аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сүлжээ <https://www.trademongolia.mn/> бэлтгэл ажлыг бүрэн хийж дуусгасан.

2021 оны 01 дүгээр сард албан ёсоор нээлтээ хийх тус сүлжээг ашиглаж ААН-үүд бизнес, бараа бүтээгдэхүүнээ таниулан сурталчлах, учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар өргөдөл гомдол гаргах, цаашлаад олон нийтээс дэмжлэг авснаар холбогдох байгууллагад хүргэж асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой болно.

Мэдээлэл үйлчилгээний нэгдсэн систем

2020 онд Танхимын цахим хуудас болон мэдээлэл үйлчилгээний системийн “Гарал үүсэл, Нэхэмжлэх, Ирсэн бичиг, Явсан бичиг” модулуудад хөгжүүлэлт хийж гишүүд болон танхимын ажилтнуудын цаг бүтээмж дээшилсэн.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дотоод хамтын ажиллагааны санамж бичиг

Төрийн болон хувийн хэвшлийн ААН-үүд, нам эвсэл, хэвлэл мэдээллийн салбарын төлөөллүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төрөл бүрийн арга хэмжээ хамтран зохион байгуулах зорилгоор дотоодын 19, гадаадын жижиг дунд үйлдвэр, худалдаа, аялал жуулчлал, тээвэр логистикийн үйл ажиллагааг дэмжих 3 байгууллагатай тус тус хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажилласан.

1. Зээлийн батлан даалтын сан
2. Гадаад харилцааны яам
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл
4. Монгол ардын нам
5. Ардчилсан нам
6. ЗТХЯ, Монголын аялал жуулчлалын холбоо

7. Үндэсний хөгжлийн газар
8. Эдикэйтэд энтерпрайз ХХК
9. Залуу бизнес эрхлэгчдийн зөвлөл
10. Хүүхдийг ивээх сан
11. Онцгой байдлын ерөнхий газар
12. Монголын самар үйлдвэрлэгчдийн холбоо
13. Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
14. Монголын менежментийн холбоо

Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах санамж бичгийг шинэчлэн байгуулав.

Санамж бичгийн хүрээнд:

- “Монгол Экспорт” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх,
- Монгол Улсын бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг гадаадад сурталчлан таниулах, Монголын брэнд бүтээгдэхүүн бий болгох хүрээнд олон улсын үзэсгэлэн, холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулж, мэдээлэл солилцох,
- Гадаад худалдааг хөгжүүлэх нэг цонхны бодлогыг хамтран хэрэгжүүлэх,
- Монгол Улсаас бусад улстай байгуулж буй хоёр талын болон бүс нутгийн Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг бизнес эрхлэгчдэд сурталчлах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах,
- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон холбогдох бусад хэлэлцээрүүдийг Монгол Улсад хэрэгжүүлэх чиглэлээр талууд идэвхтэй хамтран ажиллахаар тусгасан.

Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг

1. БНХАУ-ын Вү Ши хотын Засгийн газар
2. ӨМӨЗО-ны Улаанцав хотын ОУ-ын тээвэр ложистикийн “Бэй Фанг Лу Ганг” компани
3. COSME /жигиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан Европын хөтөлбөр/

Гадаад хамтын ажиллагааны уулзалт

- Гадаад харилцаа хамтын ажиллагааг тэлэх, эрчимжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ, Куба, Унгар, Франц, Австрали, Вьетнам, Канад, Япон, БНАСАУ, Турк, Кувейт, БНЭУ, АНУ, БНСАУ, Чех, Казакстан зэрэг улсуудын Элчин сайдуудтай уулзалт хийсэн.
- Мөн Тайпэйн Худалдаа, Эдийн засгийн төлөөлөгч, Европын холбооноос МУ-д суугаа төлөөлөгч, НҮБ-ын суурин төлөөлөгч, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь төлөөлөгч болон Жайка, Котра, Жетро, Койка байгууллагуудын төлөөлөгч нартай уулзалтууд хийсэн.
- Францын хувийн хэвшлийн томоохон төлөөлөл болох Францын ажил олгогчдын холбоо MEDEF-тэй шинэ харилцаа холбоог эхлүүлж анхны цахим бизнес уулзалтыг ХАА-н чиглэлээр амжилттай зохион байгуулсан.
- Сингапурын Бизнес Холбоотой анхны бизнес уулзалтыг амжилттай зохион байгуулсан

СУДАЛГАА

МҮХАҮТ-аас тогтмол явуулдаг “Бизнес итгэлийн индекс-2019”, “Монголын бизнесийн орчин 2020” болон Ковид-19 цар тахлаас шалтгаалан үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор бизнес, ажлын байр мөн зарим салбарт үзүүлж байгаа нөлөөлөл, учирч болох эрсдэл, шаардлагатай арга хэмжээний талаар нийт 11 судалгаа явуулсан.

2020 онд явуулсан судалгаануудад нийт 20,000 гаруй ААН, хувиараа бизнес эрхлэгчид болон иргэд хамрагдсан байна.

Ковид-19 бизнес дэх нөлөөллийн судалгаанууд

Монгол улсад вирус халдвартай холбоотой хорио цээрийн арга хэмжээг авсан цагаас бизнес ба ажлын байранд үзүүлж байгаа үр нөлөөний судалгаануудыг хийсэн. Үүнд:

- Бизнес үзүүлэх нөлөөний судалгааны тайлан
- Ажлын байрны нөлөөллийн судалгааны тайлан
- Түрээсийн бизнес дэх нөлөө, авах арга хэмжээний санал
- Эм хангамж дах нөлөө, авах арга хэмжээний санал
- Монгол улсын ноолуурын зах зээлийн 2020 оны төлөв байдал



2020 оны 3 дугаар сард явуулсан Бизнес үзүүлэх нөлөөний судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ 89.5% нь маш их ба дунд түвшинд нөлөөлсөн байгаа бол дөнгөж 2.2% нь нөлөөлөөгүй байна. Бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулан асуухад 57.7% нь бараа үйлчилгээний эрэлт буурсан, 40.1% нь тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон гэж хариулжээ.



Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлтийн судалгаа

Covid-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ нь судалгаанд оролцогсдын гэр бүлийн орлогод 73 хувьд маш их, 21 хувьд дунд зэрэг нөлөөлсөн байна. 40-49 насны, хувиараа бизнес эрхлэгч, 700 мянган төгрөг хүртэлх өрхийн орлоготой иргэдийн бүлэгт хамгийн их нөлөөлжээ. Иргэдийн гэр бүлийн аль нэг гишүүн ажлаас халагдсан тохиолдолд одоо байгаа хуримтлалаараа ямар хугацаанд амьдрах талаар тодруулахад судалгаанд оролцогсдын 72 хувь нь хадгаламж байхгүй, 14 хувь нь 1 хүртэлх сарын хугацаанд амьдрах боломжтой гэж хариулжээ.

Бизнес итгэлийн индекс 2019

Бизнес эрхлэгчдийн 2020 оны ашиг орлогын хүлээлт 36% байгаа нь өмнөх оны үр дүн болох 72% харьцуулахад 2 дахин буурсан байна. 2020 онд бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалт хийх хүлээлт нь өмнөх оноос 20 нэгж хувиар буурчээ.

Бизнесийн орчны тулгамдсан эхний гурван асуудалд бизнес эрхлэгчид зээлийн

нөхцөл, авилгал, бодлогын тогтворгүй байдал гэж нэрлэсэн нь өмнөх жилийн үр дүнтэй ижилхэн байна.



Бизнесийн орчны судалгаа 2020


Монгол Улсын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ нь 2.91 буюу дунд гэж үнэлэгдэв. Энэ нь 2017 оны судалгаатай харьцуулахад 0.46 пунктээр сайжирсан ч бизнесийн орчин хангалттай сайн биш хэвээр байна. Бизнесийн орчныг сайжруулахын тулд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх 5 арга хэмжээнд:

- Бизнесийн зээлийн хүүг бууруулах, зээлийн нөхцөлийг сайжруулах,
- Татварын таатай орчин бүрдүүлэх,
- Хууль эрхзүйн орчинг сайжруулах
- Үндэсний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих
- Авилга, хүнд суртлыг бууруулах шаардлагатай гэж бизнес эрхлэгчид үзсэн байна.



Ковид-19 Хөл хорионы үеийн аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын судалгаа

Хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 67%-д зээлийн эргэн төлөлт, 61%-д түрээсийн төлбөр, 55%-д ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих нь хамгийн



COVID-19

ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Та бүхэн 10 минут зарцуулан,
судалгаанд идэвхтэй оролцоно уу

хүндрэлтэй асуудал болсон ба Засгийн газраас 58% нь бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох, 41% нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 39% нь зээлийн хүүг бууруулах дэмжлэг шаардлагатай гэсэн байна. Мөн хөл хорио дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа сэргэхэд давхардсан тоогоор 57% нь санхүүгийн дэмжлэг, 49% нь хөнгөлөлттэй зээл авах, 44% нь зээлийн хүү бууруулах нь хамгийн хэрэгтэй байна гэж судалгаанд оролцогсод хариулсан.

Судалгааны тайлангууд болон судалгааны үр дүнд үндэслэн гаргасан санал зөвлөмжүүдийг Улсын их хурал, Засгийн газар, холбогдох яам байгууллагуудад хүргүүлсэн.

АРГА ХЭМЖЭЭ



"Эдийн засгийн коридорт чөлөөт бүс холбогдох нь" сэдэвт хөрөнгө оруулагчдын форум

Тус форумд Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, МҮХАҮТ, чөлөөт бүсүүдийн нэгдсэн зөвлөл, "Алтанбулаг" чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын зөвлөл, яам, агентлагуудын төлөөлөл, чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн төлөөлөл, БНХАУ-ын ӨМӨЗО-ны "Баяннуур хотын төлөөллүүд оролцож чөлөөт бүсийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хүнд суртал, гаалийн татварын хөнгөлөлт болон Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаарх асуудлуудыг тал талаас нь нээлттэй ярьж хэлэлцэв.

Орон нутгийн хөгжилд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа" чуулган

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран "Орон нутгийн хөгжилд төр хувийн хэвшлийн



хамтын ажиллагаа" чуулганыг Эрдэнэт хотноо зохион байгуулсан. Чуулганд төр ба хувийн хэвшлийн 400 гаруй төлөөлөл оролцож орон



нутгийн 100 орчим үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа явагдсан.

Энэтхэг-Монголын бизнесийн хамтын ажиллагаа арга хэмжээ

Монгол Улс Бүгд Найрамдах Энэтхэг улстай дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн хүрээнд "Энэтхэг-Монголын бизнесийн хамтын ажиллагаа" арга хэмжээ зохион байгуулж 200 гаруй бизнес эрхлэгч оролцсон.



Арга хэмжээнд МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин, БНЭУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён М.П.Сингх болон албаны төлөөлөгчид хүрэлцэн ирж 2 орны цаашдын хамтын ажиллагаа, бизнесийн боломжуудын талаар хэлэлцсэн.



Хандив тусламжийн арга хэмжээ

- МҮХАҮТ нь гишүүн байгууллагууд болон нийт бизнес эрхлэгчдийг уриалан БНХАУ-ын ЭСЯ-нд 140 сая төгрөг хандивлав.



- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар, ГХЯ-ны сайд Цогтбаатар АНУ-ын талтай холбогдож, Танхимын зүгээс хувийн аж ахуйн нэгжүүдээ зохион байгуулан ажиллаж 1 сая ам.долларын үнэ бүхий 60,000 ширхэг нэг удаагийн эрүүл мэндийн хамгаалах хэрэгслийг АНУ-д хандивлалаа.



- ЭМЯ, ЧД-ийн эрүүл мэндийн төвд амны хаалт, түргэн оношлуур, ОБЕГ, Тээврийн цагдаагийн албанд амны хаалт хандивлав.

МАЙ-1 тайван жагсаал

МҮХАҮТ-аас тавдугаар сарын 1-ний өдрийг “Ажлын байрны өдөр” болгон зарлан Корона вирусээс үүссэн эдийн засгийн хямралыг даван туулахыг уриалж Спортын төв ордны гадна талбайд 1000 гаруй “Эзнээ хүлээсэн багаж хэрэгслийн жагсаал” цахим орчинд “Монголын ажилтай иргэдийн



төлөө нэгдэцгээе” жагсаалыг тус тус зохион байгуулсан. Тайван жагсаалд 20000 гаруй иргэн, 2000 гаруй ААН хамрагдсан.

ТОП-100 аж ахуйн нэгж

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран Монгол Улсын ТОП-100 ААН-ийг эрэмбэлж, өргөмжлөх үйл ажиллагааг 19 дэх жилдээ амжилттай зохион байгуулсан. Тус үйл ажиллагааг анх удаа цахим хэлбэрээр зохион байгууллаа.



ТОП ААН-ээр 15 дахь удаагаа өргөмжлөгдсөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын санаачилгаар МҮХАҮТ хамтран “ТОП-10 ААН-ийн хамтын ажиллагааны уулзалт” Эрдэнэт хотноо 2020 оны тавдугаар сарын 29-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Уулзалтад Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэс



таван толгой ХК, Оюу толгой ХХК, ХААН банк, М Си Эс групп, Петровис ойл ХХК, Голомт банк, Улаанбаатар төмөр зам ХНН, Шунхлай ХХК, МҮХАҮТ-ын удирдлагууд оролцож цар тахлаас иргэдийг хамгаалах, үүссэн нөхцөл байдал, эдийн засагт тулгарч буй эрсдэлийг удирдах, эдийн засгийг сэргээх, эрчимжүүлэх чиглэлээр шинэ Засгийн газарт тавих санал зөвлөмжийг гаргаж, Монгол Улсын хөгжлийн төлөөх Хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурлаа.

МҮХАҮТ-ын үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойн арга хэмжээ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг “Дэвшилд хөтөлсөн жаран” уриан дор тэмдэглэж, ойн баярын хурал, ёслолын концерт, фото зургийн үзэсгэлэн гаргах зэрэг

арга хэмжээг зохион байгуулсан. Монголын бизнесийн салбарын тэргүүлэх 1000 гаруй бизнес эрхлэгч, Олон Улсын байгууллагын төлөөлөл, ЭСЯ-д болон Танхимын үе үеийн удирдлагууд болон ахмадууд оролцов.



Ойн хүрээнд танхимын 60 жилийн ололт, амжилт, сургамжийг нэгтгэн “Дэвшилд хөтөлсөн жаран”, Монголын шилдэг ААН-үүдийн замналыг эмхтгэн “ТОД-60” номууд хэвлэгдэн гарсан.

Монголын олон улсын арбитрын 90 жилийн ойн арга хэмжээ



Монгол улсад арбитрын байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ. 90 жилийн хугацаанд Арбитр нь бизнесийн гэрээнээс үүдэлтэй хэрэг маргааныг шүүхэд очилгүйгээр, нэг шаттай хэлэлцэж, дэлхийн 160 гаруй оронд хүчин төгөлдөр шийдвэр гаргадаг байгууллага болон хөгжсөн билээ.

Татварын хуулийн хэрэглээ нээлттэй хаалганы өдөрлөг

МҮХАҮТ болон Монголтакс ТМЗ ХХК хамтран татвар төлөгчдөд зориулсан татварын багц хуулийн хүрээнд татвар, санхүүгийн



эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн удирдлага болон төлөвлөлтийн чиглэлээр нэг өдрийн үнэ төлбөргүй зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан.

“Гааль-бизнесийн түншлэл-2020” уулзалт

Уулзалтад ГХЯ, ГЕГ, МХЕГ-ын төлөөлөл болон бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн 100 гаруй хүн оролцов. Уулзалтаар “Гаалийн зэрэгцүүлэлт”, “Интернетээр өөрөө мэдүүлэх”, “Интернет бүрдүүлэлтийн ач холбогдол” сэдвээр танилцуулга хийж, “Интернет бүрдүүлэлт”, “Экспорт, импортын бүрдүүлэлт болон гаалийн тариф, татвар”, “Гаалийн үнэлгээ”, “Лабораторийн



шинжилгээ”, “Гаалийн шинэчлэл”, “Худалдааг хөнгөвчлөх” гэсэн 6 сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцов.

Европын холбооны худалдааны өдөр

Гурав дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Европын Холбооны худалдааны өдрүүд” арга хэмжээнд төр, хувийн хэвшлийн 400



орчим төлөөлөгчид оролцож худалдааны бодлого, худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус гаралтай барааны экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импорт, экспортын бүрдүүлэлтийн чиглэлээр санал солилцлоо.

Бизнес лиг-2020

МҮХАҮТ-ын 60 жилийн ойн хүрээнд Танхимын гишүүн байгууллага, ажилтан,



албан хаагчдын дунд сагсан бөмбөгийн “Бизнес лиг- 2020” шилжин явах цомын төлөөх тэмцээнийг 6 дахь жилдээ зохион байгуулж, Макс Групп ХХК ивээн тэтгэгчээр, Монголын сагсан бөмбөгийн мэргэжлийн шүүгчдийн холбоо хамтран зохион байгуулагчаар ажилласан .

Тэмцээнд анх удаа эмэгтэй баг оролцсон ба 24 байгууллагын 24 эрэгтэй, 8 эмэгтэй нийт 32 багийн 400 гаруй тамирчид бүртгүүлэн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан эхний хэсгийн тоглолтуудын үеэр Монгол улсад Ковид-19 халдварт өвчин гарч Засгийн газар, УОК-ын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсний улмаас тус тэмцээн тодорхойгүй хугацаагаар хойшилсон.

Үндэсний чанарын шагналын болзол хангасан ААН-үүдийг тодруулав

Олон улсын чанарын өдрийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг Үндэсний чанарын шагналд нийт 33 аж ахуйн нэгж байгууллагын 45 материалыг 3 номинацаар шалгаруулж, Шадар сайдаар баталгаажуулсан.

“Монголын чацаргана – Дэлхийн зах зээлд” чацарганын кластерын анхдугаар форум

Чацарганын кластерын нээлт, анхдугаар форумд төрийн байгууллагын төлөөлөл, чацаргана тариалдаг, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортолдог компани, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 100 гаруй хүн оролцсон.



Жимсний салбарт төрөөс баримтлах бодлого, чацарганын бүтээгдэхүүний экспортын төлөвийн талаар хэлэлцэв.

Executive summit virtual event 2020

МҮХАҮТ-ын зүгээс бизнесийн хөгжлийг дэмжих 1000 CEO, 1000 хүчирхэг компани хөтөлбөрийн хүрээнд компанийн гүйцэтгэх удирдлагуудад шинэ сорилтод шийдэл болгож дэлхийн бизнесийн шилдэг контентуудыг хүргэх, үндэсний компаниудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, тасралтгүй суралцах боломжийг дэмжих зорилгоор анх удаа “EXECUTIVE SUMMIT 2020” гүйцэтгэх удирдлагын виртуал уулзалтыг амжилттай зохион байгуулав.



ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

Дотоод үзэсгэлэн Улаанбаатар Түншлэл – 2020 олон улсын үзэсгэлэн яармаг

МҮХАҮТ-ын 60 жилийн ойн хүрээнд МҮХАҮТ, НЗДТГ-тай хамтран 45 дахь жилдээ “Улаанбаатар Түншлэл” олон улсын үзэсгэлэн яармагийг зохион байгууллаа. Уг үзэсгэлэнд дотоодын 150 ААН, ӨМӨЗО-ны Баяннуур хот зочноор оролцсон.



Солонгос, Монголын шилдэг аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний үзэсгэлэн

БНСУ, Монгол улс хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн хүрээнд БНСУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яам, КОТРА Улаанбаатар БНСУ-ын бизнесийн төв, Монгол улс дахь БНСУ-ын ХАҮТ-тай хамтран ХАА-н бүтээгдэхүүний үзэсгэлэн яармагийг зохион байгуулсан.



Гадаад үзэсгэлэн

ХБНГУ-ын Берлин хотноо “Олон улсын ногоон 7 хоног” үзэсгэлэн

Тус үзэсгэлэнд 75 улсын 1800 гаруй оролцогч, 10 мянга гаруй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг танилцуулсан. Монгол Улсыг төлөөлж ХХААХҮЯ, МҮХАҮТ, болон Европын Холбооны Монголын худалдааг



дэмжих TRAM төслийн төлөөллүүд хамтран анх удаагаа албан ёсоор уг олон улсын үзэсгэлэнд оролцлоо. Үзэсгэлэнд манай улсын 20 гаруй ААН бараа бүтээгдэхүүнээ танилцуулан оролцсон. Мөн МҮХАҮТ-ын дэргэдэх гоо сайхны кластер, чацарганын кластер, арьс шир болон торомны ноосны кластерын гишүүдийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулсан.

Бусад үзэсгэлэн:

1. БНХАУ-ын Тяньжин хот “Олон улсын импортын бараа бүтээгдэхүүний цахим экспо”

2. БНХАУ-ын ШУӨЗО-ны Худалдааны газартай хамтран “Шинжаан-Монголын худалдаа, эдийн засгийн цахим үзэсгэлэн, бизнес уулзалт” арга хэмжээ

3. Зүүн хойд Азийн олон улсын худалдааны дижитал экспод тус тус дотоодын аж ахуйн нэгжүүдийг цахимаар оролцуулсан.

СУРГАЛТ

МҮХАҮТ-аас Гишүүд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор урт болон богино хугацааны сургалт, албан байгууллага дээрх захиалгат сургалтуудыг зохион байгуулж 300 орчим хүнийг сургалтад хамруулсан.

1. Гадаад худалдааны менежер
2. Санхүүгийн менежер
3. CEO сургалт
4. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт
5. Сэдэвчилсэн болон захиалгат сургалтууд
6. “Ковид-19: Хууль эрх зүйн асуудал” онлайн сургалт
7. “Ковид нөхцөлд компанийн өртөг

зардал бууруулахад анхаарах зүйлс” онлайн сургалт



МҮХАҮТ нь Харвардын манлайллын хөтөлбөрийн гэрээнд гарын үсэг зурсан. Гэрээний хүрээнд Танхимын гишүүн байгууллага, ААН-үүдийн CEO, удирдах албан тушаалтнуудад манлайллын цогц сургалтын хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх боломж нээгдсэн. 2021 онд Харвардын манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Ковид-19-ийн нөлөөгөөр манай улсын экспорт, импортын хувь хэмжээ буурсан, үйл ажиллагаа нь хүндэрч “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл

байдал”-ын гэрчилгээ авсан ААН-ийн тоо өмнөх онтой харьцуулахад 15.6 дахин өссөн байна.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР

Монгол Улсад арбитрын байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойн баярын арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн арбитрын байгууллагыг нийтэд таниулах сургалтын үйл ажиллагааг тогтмолжуулж, байр танхимыг шинэчлэн засварлаж, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг арбитрчийн нэрсийн жагсаалтад шинээр бүртгэсэн зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн ойн хүрээнд арбитрын байгууллагын үүсэл хөгжлийн талаар анхны түүхэн баримтат киног олон нийтийн хүртээл болгож, дараах номуудыг эрхлэн гаргасан:

- Монгол Улс дахь Арбитрын Байгууллага: Түүхэн Товчоон
- Монгол Улс дахь Арбитрын Эрх Зүйн Баримт Бичгийн Эмхтгэл
- Арбитрын Сэдэвт Эрдэм Шинжилгээний Нийтлэлийн Эмхтгэл
- Монголын Олон Улсын Арбитрын Шийдвэрийн Түүвэрлэсэн Эмхтгэл /2012-2019/
- Гэрээний Загварууд



Арбитрын үйл ажиллагааг таниулах сургалт

ТОП аж ахуйн нэгжүүдийн удирдлага, хуулийн хэлтсийн албан тушаалтнуудад арилжааны арбитрын онцлог, үйл ажиллагааг таниулах, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгардаг олон асуудлуудын нэг болох “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал” (force majeure & hardship)-ыг хэрхэн тодорхойлох, тус гэрчилгээг авахын ашиг тусын талаар



мэдээлэл олгох сургалтыг 8 ААН-д зохион байгуулсан.


Түүнчлэн арбитрчийн нэрсийн жагсаалтад орох хүсэлтэй иргэдэд зориулсан сургалт, арбитрчдыг мэргэшүүлэх сургалт зэрэг хэд хэдэн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг нэвтрүүлэн хэрэгжүүлж нийт 9 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна.




Шинэ арбитрчдыг элсүүлэв

Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн 20 мэргэжилтнийг арбитрчдын эгнээнд элсүүлснээр Монголын Олон Улсын Арбитр нь дотоод, гадаадын нийт 95 арбитрчтай үйл ажиллагаа явуулж байна.





АРБИТРЧИЙН ТАНИЛЦУУЛГА



Д.Алтанцэцэг
LL.M.

МОНУА-ын Арбитрч
1994-2006 хооронд Арбитрын
Ерөнхий нарийн бичгийн дарга

Боловсрол

- МУИС-ийн Хууль зүйн сургууль
- ОХУ-ын Эрхүү хотын Их сургууль, Улс төрийн дээд сургууль

Мэргэшсэн салбар
Арилжааны арбитр

77277070 | 11-324820 | info@arbitr.mn | www.arbitr.mn

Мөн 2020 оноос эхлэн Монголын Олон Улсын Арбитрын нийт арбитрчдыг олон нийтэд цувралаар танилцуулж эхэлсэн. Ингэснээр арбитраар хэрэг маргаанаа хянан шийдвэрлүүлж буй талууд тухайн арбитрчийн мэргэшсэн байдлын талаар мэдээлэл авахаас гадна арбитрчаа сонгон үйлчлүүлэх давуу талыг олгож байна.

Судалгаа

Монголын Олон Улсын Арбитрын захиалгаар Хууль Зүйн Үндэсний хүрээлэнгийн судлаачдын баг Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэв.



Арбитрын ажлын өрөө тасалгаа болон хуралдааны танхимыг олон улсын арбитрын байгууллагын жишигт нийцүүлэх, нийт ажилтан болон үйлчлүүлэгчдийн тав тухыг хангах үүднээс иж бүрэн засварлан тоноглож,



арбитрын цахим хуралдаан хийх нөхцөлийг бүрдүүллээ.

Бизнесийн хэрэг, маргааныг шийдвэрлэх үйлчилгээ

2020 онд 107 нэхэмжлэл хүлээн авснаар түүхэндээ хамгийн олон шинэ хэрэг хүлээн авсан жил боллоо.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад арбитрын хэрэг маргаанд оролцож байсан эсэх талаар 315, Улсын Их Хурлын Сонгуульд нэр дэвшигчдийн 703 лавлагаа тодорхойлолт гаргаж үйлчилсэн.



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

МҮХАҮТ болон ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл

Төслийн хүрээнд Чацарганын кластер болон Хонины ноосны нэмүү өртгийг дэмжих чиглэлд сургалт, судалгаа, форум зохион байгуулж, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах, ХБНГУ руу бүтээгдэхүүн экспортлоход дэмжлэг үзүүлсэн.



Монголын худалдааг дэмжих төсөл

- Дөрвөн кластеруудын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангахад зөвлөн чиглүүлж санхүүжүүлсэн.
- МҮХАҮТ-ын удирдах ажилтан, мэргэжилтнүүд, кластерын гишүүдийг чадавхжуулах 9 дотоод сургалтуудын зохион байгуулсан.



- Экспортыг нэмэгдүүлэх болон худалдааг хөнгөвчлөх сэдвээр 13 гарын авлага, товхимол болон тараах материалыг хэвлүүлсэн.
- Кластерын гишүүн компаниудыг ХБНГУ-ын Ногоон долоо хоног, МҮХАҮТ-ын Улаанбаатар-Түншлэл олон улсын үзэсгэлэнгүүдэд оролцоход санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.
- Монголын ЖДҮ-ийн экспортын санхүүжилтийн судалгааг хийлгэсэн.
- МҮХАҮТ болон кластеруудын цахим хуудсыг хөгжүүлэх, REX системийн бүртгэлийг цахимжуулах, экспортлогчдын бүртгэлийг хийх ажилд дэмжлэг үзүүлж, кластеруудыг вэб хуудастай болгосон.
- МҮХАҮТанхим нь өөрийн вэб хуудсанд Худалдааг хөнгөвчлөх цонхыг нээж 2020-2021 онд хэрэгжих Дэлхийн худалдааны байгууллагын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн (ХХХ) талаар олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилттэй холбоотой мэдээллүүдийг бизнес эрхлэгчдэд хүргэж эхэлсэн.

МҮХАҮТ-ын ажилтнуудын цахим сургалтын техник хэрэгслийг сайжруулах, ЖДҮ эрхлэгч болон МСҮТ төгсөгчдийн

ур чадварыг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж цахим сургалт зохион байгуулахад шаардлагатай техник, технологийн хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн.

“Эмэгтэйчүүдийг эдийн засгаар чадавхжуулах” төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр шалгарч нийслэлийн хоёр дүүрэг, (Сонгинохайрхан, Налайх),



Asian Development Bank

гурван аймгууд (Увс, Сүхбаатар, Сэлэнгэ)-ын зорилтот нийт 100 эмэгтэйчүүдэд бизнес, санхүү, хувь хүний хөгжлийн сургалт зохион байгуулж, 50 эмэгтэйн бизнес санааг чиглүүлж ажилласан. Төслийн үр дүнд 25 эмэгтэйн амжилттай хэрэгжүүлсэн төслийн түүхийг бий болгоно.

Орон нутгийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой Органик Монгол хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, органик, тогтвортой хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хаягдал багатай үйлдвэрлэлийн төслийн сонгон шалгаруулалт явагдаж, 11 төсөлд санхүүжилт олгосон.



Ерөнхий чиглэлээр:

1. Эдийн засгийн бодлогын зөвлөл
2. Хууль зүйн бодлогын зөвлөл
3. Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл
4. Комплаенсийн үндэсний зөвлөл

Салбарын бодлогын чиглэлээр:

1. Экспортыг дэмжих зөвлөл
2. Импортлогчдын зөвлөл
3. Худалдааг хөнгөвчлөх, тээвэр ложистикийн зөвлөл
4. Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл
5. Ноос ноолуурын зөвлөл
6. Аялал жуулчлалын зөвлөл
7. Итгэмжлэгдсэн лабораториудын зөвлөл
8. Франчайзингийн зөвлөл

Бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр

1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл
2. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл
3. Гарааны бизнесийг дэмжих зөвлөл
4. Бизнес эрхлэгч залуучуудын зөвлөл


Хамтын ажиллагааны чиглэлээр:

1. Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл
2. ОХУ-тай хамтран ажиллах зөвлөл
3. Хятад улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
4. Япон улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
5. Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл
6. Монгол Туркийн хамтарсан танхим

**МҮХАҮТ-ААС ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦДОГ ГОЛ ХОРОО, ЗӨВЛӨЛ
АЖЛЫН ХЭСГИЙН ЖАГСААЛТ**

дд	Ажлын хэсэг, зөвлөл, хорооны нэр	Байгууллага
1	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл	Монгол улсын Засгийн газар
2	Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үүнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, иргэний нийгмийн хамтарсан зөвлөл	Монгол улсын Засгийн газар
3	Залуу бизнес эрхлэгч, стартап, энтрепренеруудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйг орчинг бий болгох санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар
4	Хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг	ХЗЯ
5	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсэг	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо
6	Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо
7	Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо	ЗГХЭГ, ҮХГ
8	"Монголын мянганы сорилтын сан"-гийн удирдах зөвлөл	ГХЯ
9	Экспортыг дэмжих зөвлөл	ГХЯ
10	Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг "Нэг цонх"-ны бодлогоор хөгжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	ГХЯ
11	Дэлхийн худалдааны байгууллагад Монгол улсын худалдааны бодлого хянуулах ажлын хэсэг	ГХЯ
12	Хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг	ХЗДХЯ
13	Арилжааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг	ХЗДХЯ
14	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн боловсруулах ажлын хэсэг	ХЗДХЯ
15	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг	ХЗДХЯ
16	Худалдааны тухай хуулийн төсөл, Үзэл баримтлалын төсөл боловсруулах ажлын хэсэг	ХХААХҮЯ
17	Гаалийн тарифын зөвлөл	СЯ
18	Хилийн боомтын үндэсний зөвлөл	СЯ
19	Бичил жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг	Монгол банк
20	"Зээлийн батлан даалтын сангийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг	ЗБДС
21	ШӨХТГ-ын ШӨХТГ-ын дэргэдэх зөвлөл	ШӨХТГ
22	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл	Монгол улсын Засгийн газар
23	МУ-ын түүх, соёл, урлаг, өв уламжлал, байгаль газар нутгаа дэлхий дахинд сурталчлан таниулах замаар Монгол эх орноо гадаад улс оронд сурталчлах ажлыг үе шаттай эрчимтэй зохион байгуулах цогц санал, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсэг	Монгол улсын Засгийн газар
24	Ардын хувьсгалын 100 жилийн ойн арга хэмжээнд бэлтгэх, ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг	Монгол улсын Засгийн газар
25	Итгэмжлэлийн техникийн дэд хороо	Үндэсний итгэмжлэлийн төв
26	Чанарын удирдлагын техникийн дэд хороо	СХЗГ

ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ХИЙСЭН АЖЛУУД



Монгол улсын Засгийн газраас Ковид-19 вирусийн халдварын тархалтыг зогсоох зорилгоор Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, хатуу хөл хорион тогтоосон даруйд МҮХАҮТ-аас эдийн засаг бизнест үүссэн хүндрэлийг даван туулах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар 5 бүлэг 21 саналыг гаргаж, Монгол улсын Их хурал, Засгийн газарт танилцуулсан бөгөөд энэ нь татвар, нийгмийн даатгалын төлөлтийг хойшлуулах, зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, цахилгаан дулаан усны зардлыг төрөөс төлөх зэрэг шийдвэрүүд гаргахад үр нөлөөгөө үзүүлсэн.

Танхимаас 2020 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд хатуу хөл хорионы үед бизнесийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааг явуулж, 3530 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулсан ба судалгааны тайланг гаргаж УИХ, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ба олон нийтэд мэдээлсэн.

Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисстой хамтран ажиллах чиглэлээр:

Улсын онцгой комиссын шуурхай штабын удирдлага ба танхимын Удирдах зөвлөлийн гишүүд, бизнес эрхлэгчдийн төлөөллийн цахим уулзалтыг 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. УОК-оос гарч байгаа мэдээллийг цаг алдалгүй бизнес эрхлэгчдэд хүргэх, бизнес эрхлэгчдэд тулгарсан асуудлыг түргэн шуурхай шийдвэрлүүлэх зорилгоор УОК-ын шуурхай штаб дээр Танхимаас нэг ажилтанг нэг сарын хугацаанд ажиллуулсан.

УОК, НОК-той удаа дараагийн цахим уулзалт зохион байгуулж, Ковид-19 цар

тахлын эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт зөвшилцсөнөөр орж ажилласан.

Мөн танхимаас Статистикийн төв газраас гаргасан тоон мэдээллүүдэд тулгуурлан 614 салбар чиглэлийг үйл ажиллагаагаар багцлан халдвар, хамгааллын тархах нөхцөлд тулгуурлан 5 шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийг тодорхойлж эрэмбэлэн гаргаж НОК-т хүргүүлсэн.

Танхимын удирдах зөвлөлийн гишүүд, бизнес эрхлэгчдийн Ономсангийн тэргүүн Наранбаатартай хийсэн уулзалтыг зохион байгуулж, Ковид-19 цар тахлын талаар авч хэрэгжүүлж буй олон улсын туршлага, "Ономсан"-ийн санаачлагуудын талаар санал солилцсон.

Бизнесийн зөвлөх зөвлөл

Монгол Улсын Шадар Сайдын 2020.12.08-ны өдрийн 153 тоот тушаалаар "Бизнесийн зөвлөх зөвлөл" байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнд нь Зөвлөлийн даргаар МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин, орлогч даргаар Шадар сайдын зөвлөх Ц.Уламбаяр, гишүүдэд мэргэжлийн холбоодын төлөөллүүд болон танхимын Удирдах зөвлөлийн гишүүд багтсан,

Бизнесийн зөвлөх зөвлөлийн эхний уулзалтыг 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан Замын-Үүд, Алтанбулаг хоёр боомт дээр үүсээд байгаа асуудал, хүндрэлийг шийдвэрлэх, цаашид уг боомтуудаар ачаа тээврийг зохицуулах асуудлаар зохион байгуулсан бөгөөд Монгол улсын шадар сайд Я.Содбаатар оролцсон. Уг уулзалтын үр дүнд Замын-Үүд, Алтанбулаг боомт, Эм хангамж, Махны экспортод тулгарсан асуудлыг шийдвэрлэх 4 ажлын хэсэг байгуулагдаж амжилттай ажилласан.



Замын –Үүд боомтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

Замын-Үүд-Эрээн хотод импортын бараа бүтээгдэхүүний автомашины бөөгнөрөл үүсэж, хүнсний бараа бүтээгдэхүүн их хэмжээгээр саатсантай холбоотойгоор Эрээнээс хүнсний бүтээгдэхүүн ачих аж ахуйн нэгжүүдийн эрэмбэ дарааллыг тогтооход дэмжлэг үзүүлэх хүсэлтийг ХХААХҮЯ, Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсний дагуу түр хугацаанд хариуцан ажилласан ба Аж ахуйн нэгжүүдийн хүсэлтүүдийг хүлээн авч, ачаа ачуулах ААН-ийн нэрсийг гарган Авто тээврийн үндэсний төвийн Замын-Үүд дэх салбарт хүргүүлж тодорхой хугацаанд ажилласан. Шадар сайдын тушаалаар Замын үүд-Эрээний боомтоор ачаа тээврийн нэвтрэх чадварыг өсгөх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан.

Алтанбулаг боомтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

Засгийн газраас Алтан булаг боомтыг хаах шийдвэрийг гаргахаас өмнө замд гарч, хил дээр тулж ирсэн жолооч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүний татан авалтын асуудлаар ЗТХЯ, МТЗНХ, МАТНХ, МЭЗБНХ болон бусад байгууллагатай хамтран ажилласан ба 4 ажлын хэсэгт танхимын төлөөллүүд орж ажилласан. Хил хаах шийдвэр гарсан өдрөөс эхлэн 210 тээврийн хэрэгслийн судалгааг гаргасан ба энэхүү судалгааны мэдээллийг 2 дахин шинэчилж хүргүүлсэн бөгөөд тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хүсэлтийг УОК, ЗТХЯ-д удаа дараа тавьж шийдвэрлүүлсэн.





МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



📍 Монгол Улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг,
15-р хороо, Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр

☎ Утас: (+976) 77277070

☎ Факс: (+976) 11 324620

🌐 www.mongolchamber.mn

📘 [mongolchamber](https://www.facebook.com/mongolchamber)

✉ chamber@mongolchamber.mn

🐦 [mongolchamber](https://www.twitter.com/mongolchamber)